

ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

CURRENT SITUATION AND FUTURE TRENDS OF TAX EVASION CRIMES

Г.Анхбаяр

Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Санхүү, татварын гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч

Товч агуулга: Монгол Улс дахь татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцөл, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр дагавар, чиг хандлагыг тодорхойлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар дурдсан.

Улсын хэмжээний статистик мэдээллээс үзэхэд, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн гаралт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Энэ нь татварын бодлого, хяналтын механизмын сул, татварын ачаалал, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг хүчин зүйлээс шалтгаалж байна. Иймд татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг илрүүлэхэд орчин үеийн технологийн дэвшлийг ашиглах, олон улсын туршлагыг нэвтрүүлэх, татварын болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Abstract: This research aims to examine the current state of tax evasion crimes in Mongolia, their impact on society and the economy, and future trends. The study analyzes the causes and influencing factors of tax evasion crimes, as well as shortcomings in the legal framework.

In recent years, the incidence of tax evasion crimes in Mongolia has been increasing due to weaknesses in tax policies and control mechanisms, high tax burdens, and economic instability. To address this issue, it is essential to enhance the enforcement of tax laws, improve monitoring systems, leverage modern technological advancements for crime detection, adopt international best practices, and strengthen cooperation between the government and taxpayers. Implementing these measures can help reduce the prevalence of tax-related crimes and prevent future occurrences.

Түлхүүр үгс: Татвар, эдийн засгийн гэмт хэрэг, эрх зүйн зохицуулалт, хяналтын тогтолцоо, татварын бодлого.

Keywords: Tax, economic crime, legal framework, monitoring system, tax policy.

Үндсэн хэсэг

Татвар нь улс оршин тогтнох үндэс суурийн нэг бөгөөд түүхэн цаг үеэс одоог хүртэл төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах гол хүчин зүйл байсаар ирсэн. Иймээс олон улсад татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг нийгэм, эдийн засагт ноцтой хор уршиг учруулдаг хэмээн үзэж, гэмт хэрэгт тооцдог.

Уламжлалт гэмт хэрэг нь хувь хүн, бүлэг хүмүүсийн ашиг сонирхлыг хөнддөг бол татварын гэмт хэрэг нь улс орны эдийн засгийн аюулгүй байдал, тусгаар тогтнолд заналхийлдэг. Нийгмийн хор аюул нь улсын болон орон нутгийн төсөвт орж ирэх мөнгөн хөрөнгийн урсгалыг хааж, төсвийн бодлогод сөргөөр нөлөөлж, нийгэм, соёл, эдийн засгийн тэргүүлэх бусад салбар, батлан хамгаалах, боловсрол, эрүүл мэндийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, нийгмийг хямрал, тогтворгүй байдалд хүргэх эрсдэлтэй.

Татвар төлөхөөс зайлсхийх гэдэг нь хувь хүн эсвэл байгууллага хууль ёсоор төлөх ёстой татвараа санаатайгаар төлөхгүй байх үйлдлийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, татвар төлөгч нь хуульд заасан арга хэрэгслээр хамгийн бага татвар төлөхийг эрмэлздэг. Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн хуурамч тайлан гаргах, орлогоо нуун дарагдуулах, худал мэдүүлэх, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэрэг олон хэлбэртэй. Түүнчлэн, зөвхөн улсын төсөвт санхүүгийн хохирол учруулаад зогсохгүй, эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулж, улс орны сөрөн тэсвэрлэх чадварт сөргөөр нөлөөлдөг.

Сүүлийн жилүүдэд татвараас зайлсхийх арга хэлбэр улам нарийсаж, зохион байгуулалттай болж байна. Тухайлбал, татвараас зайлсхийхийн тулд санхүүгийн зэрэгцээ бүтэц бүрдүүлэх, охин компани болон хуурамч аж ахуйн нэгж байгуулах гэх мэт хандлага ажиглагдаж байна. Далд эдийн засгийн мөнгөн хөрөнгийн урсгалын нэг эх үүсвэр нь татварын албанд мэдэгдэлгүйгээр санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх үйлдлээр илэрч байна.

Татвар нь улсын төсвийг бүрдүүлэх, эдийн засгийн хөгжлийн түвшинг тодорхойлох хүчин зүйл болохын зэрэгцээ төрийн үйл ажиллагааг тогтвортой явуулах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээний үндэс болдог. Иймээс татвар төлөх үүргийг хууль эрх зүйн хүрээнд зохицуулж, эрүүгийн эрх зүйгээр хамгаалах замаар зөрчигдөхөөс урьдчилан сэргийлдэг.

Монгол хэлний их тайлбар тольд “татвар” гэдэг үгийг “татварлаж авах зүйл, оноож авах зүйл” хэмээн тайлбарлажээ.¹

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь хэсэгт “албан татвар” гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ гэж тодорхойлжээ.²

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг бүс нутгийн болон олон улсын хэмжээнд үйлдэгдэж буйгаар нь ангилж болно. Бүс нутгийн татварын зөрчил нь тухайн улсын дотоодын хууль тогтоомжийг зөрчин үйлдэгддэг бол олон улсын татварын зөрчил нь татварын таатай орчныг ашиглаж, өөр улсад бүртгэлтэй компани байгуулах, оффшор бүсэд хөрөнгө нууцлах хэлбэрээр илэрдэг. Мөн хувь хүн болон байгууллагын татварын зөрчил гэсэн ангилалд хувааж болно. Хувь хүний татварын зөрчилд орлогоо нуух, тайлангаа худал мэдүүлэх зэрэг үйлдлүүд хамаарах бол байгууллагын татварын зөрчил нь компанийн ашиг орлогыг зориудаар багасгах, зохиомол зардал бүрдүүлэх зэргээр илэрдэг.

Олон улсын түвшинд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор хэд хэдэн арга хэмжээ хэрэгжиж байна. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ийн татварын ил тод байдлын стандарт нь улс орнуудын хооронд мэдээлэл солилцох үйл явцыг зохицуулдаг бол Санхүүгийн арга хэмжээ авах ажлын хэсэг (FATF) нь мөнгө угаахтай холбоотой татварын гэмт хэргийг илрүүлэхэд анхаарч байна.

Эрүүгийн хуулийн 18.3 дугаар зүйлд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг хуульчилсан.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь ихэвчлэн шууд санаатайгаар үйлдэгддэг бөгөөд орлого, ашиг болон эд хөрөнгийг нуух, татварын хуурамч тайлан мэдүүлж төрөөс төлөх татварын хэмжээг санаатайгаар бууруулах, зохиомол зардал үүсгэх зэрэг хэлбэрээр илэрдэг.

Объект: Албан татвар төлөх талаар тогтоосон журам байна. Энэ төрлийн гэмт хэргийн объект нь төрийн төсвийн орлого, татварын шударга тогтолцоо, эдийн засгийн аюулгүй байдал бөгөөд зөрчсөн тохиолдолд тухайн улсын санхүүгийн тогтвортой байдал,

¹ Монгол их их тайлбар толь

² Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь хэсэг

эдийн засгийн өсөлт, нийгмийн үйлчилгээний хүртээмж алдагдах олон талын сөрөг үр дагавартай.

Объектив шинж: Тодорхой үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрч болно. Үйлдлийн хувьд татварын тайланг санаатай худал мэдүүлэх, хуурамч баримт бүрдүүлэх, орлогоо зориудаар нуух, зохиомол зардал үүсгэх зэрэг хэлбэртэй байна. Харин эс үйлдэхүй нь татварын тайланг хугацаанд нь мэдүүлэхгүй байх, шаардлагатай мэдээллийг өгөхөөс зайлсхийх байдлаар илэрдэг.

Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, татвар төлөх үүрэг бүхий хувь хүн, аж ахуйн нэгж, компани, бизнес эрхлэгч, хуулийн этгээд байна. Мөн байгууллагын удирдлагууд, санхүүгийн мэргэжилтнүүд, нягтлан бодогчид татвараас зайлсхийх гэмт хэрэг үйлдэхэд оролцсон тохиолдолд хамтран оролцогчийн хувиар эрүүгийн хариуцлага хүлээдэг.

Субъектив шинж: Гэмт хэрэгт холбогдсон этгээд санаатай үйлдэл гаргасан эсэхээр тодорхойлогдоно. Гэм буруутай этгээд нь татвар төлөх үүрэгтэй гэдгээ мэдсээр байж санаатайгаар орлогоо нуух, хуурамч мэдээлэл өгөх замаар татварын хуулийг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэлтэй болно.

Гэмт үйлдлийн арга. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь хувь хүн, аж ахуйн нэгж, олон улсын корпорациудаас янз бүрийн үйлдлийн аргаар үйлдэгддэг. Орлогоо нуух, хуурамч зардал бүрдүүлэх, оффшор бүс ашиглах, татварын тогтолцоог хууль бусаар ашиглах, санхүүгийн гүйлгээг олон шатлалт схем байдлаар төвөгтэй болгох гэх мэт хэлбэрээр илэрдэг. Тухайлбал,³

1. Үйл ажиллагаанаас олсон орлогыг санхүүгийн баримт бичигт тусгахгүй, ажил үйлчилгээгээр олсон эсвэл солилцоогоор авсан эд хөрөнгийг байгууллагын эд хөрөнгө, орлогод бүртгэж авахгүй байх;

2. Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуун дарагдуулах;

3. Ажил үйлчилгээний төлбөрт авсан эд хөрөнгийг татварын тайланд тусгахгүй, орлогод бүртгэхгүй бусдад шилжүүлэх;

4. Татвар ногдох орлого, орлогоос бусад татвар ногдох зүйлийн тоо хэмжээ, үнийг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тайланд багасгаж тусгах, ийнхүү багасгахын тулд зардал болон бусад хасагдах зүйлийг үндэслэлгүйгээр өсгөх;

5. Нягтлан бодох, анхан шатны бүртгэл, татварын тайлан, холбогдох баримт бичгийг устгах, нуух, нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, холбогдох баримт бичгийг бүрдүүлэлгүй, татварын тайлан гаргах боломжгүй болгох;

6. Хуулийн этгээдийн нэр, хаяг, тамга, тэмдэг, данс, улсын бүртгэлийн гэрчилгээ, зөвшөөрөл, эд хөрөнгө, баримт бичгийг бусдад шилжүүлэх, ашиглуулах замаар бусдад татвар төлөхөөс зайлсхийх боломж бүрдүүлэх;

7. Аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн дагуу авч байгаа татвар ногдох орлогыг хувь хүний харилцах дансаар авах, бэлнээр авах, хуурамч НӨАТ (цаашид нэмэгдсэн өртгийн албан татвар гэх)-ын падаан бичиж өгөх байдлаар орлогоо нуун дарагдуулах;

8. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах, бэлэглэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлж, орлогоо нуун далдлах, хэлбэр дүрсийг нь өөрчлөх хэлбэрээр эзэмшил, өмчлөлд авах;

³ “Эдийн засгийн гэмт хэргийг илрүүлэх аргачлал, онол, практик”, Цагдаагийн ерөнхий газар, 33-35 дугаар тал, Улаанбаатар хот 2018 он

9. Импортлож байгаа бараа материалын тоо, хэмжээг бууруулах, эсхүл үнийг өсгөх замаар гаальд худал мэдүүлэх, бага хэмжээний татвар төлөх;

10. Импортоор орж ирсэн бараа материалын чанар стандартыг өөрчлөх замаар гаалийн тухай хууль, журамд заасан нөхцөлийг зориудаар бий болгож, гаалийн татварын хөнгөлөлт эдлэх, бага хэмжээний татвар төлөх;

11. Бараа материал худалдах, худалдан авахдаа хувь хүний нэрээр гэрээ байгуулах, импортоор оруулж ирэх, эсхүл огт гэрээ хэлцэл хийхгүйгээр худалдан авсан бараа материалын үнийн дүнг худал мэдүүлэх байдлаар орлогоо нуух;

12. Аж ахуйн нэгжүүд нь арилжааны банкнуудад хэд хэдэн данс нээж татвар ногдох орлогыг банк хоорондын олон удаагийн гүйлгээгээр зарлага мэтээр гаргах;

13. Шинээр охин компани байгуулан үйл ажиллагаа явуулах байдлаар үндсэн компанийн татвар ногдох орлогыг багасгах;

14. Ажилтны тоог зохиомлоор нэмэгдүүлж, цалин хөлс, шагнал урамшуулал, үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх;

15. Үндсэн хөрөнгийн нэр төрөл, өртгийг бага үнэтэй түргэн эдлэгдэж хорогдох эд хөрөнгийн өртөгт оруулах замаар зардлаа өсгөх;

16. Бэлэн тооцоогоор бараа материалыг худалдаж авах, борлуулах байдлаар тайланд тусгахгүй байх;

17. Татварын хөнгөлөлтийг хууль бусаар авах зэрэг үйлдлийн аргаар үйлдэгдэж байна.

Түгээмэл хэрэглэгддэг арга нь орлогоо санаатайгаар нуух явдал бөгөөд ихэвчлэн татварын тайланг худал мэдүүлэх, давхар бүртгэл хөтлөх, бэлэн орлогоо тайланд тусгахгүй байх замаар хэрэгждэг. Зарим аж ахуйн нэгжүүд борлуулалтын орлогоо бодит байдлаас бага дүнтэй тайлагнах, эсвэл тодорхой хэмжээний орлогыг огт тайлагнахгүй байх аргыг хэрэглэдэг. Мөн, аж ахуйн нэгжүүд татвараас зайлсхийхийн тулд хуурамч зардал бүрдүүлэх аргыг өргөн ашиглаж байна.

Зарим тохиолдолд хамаарал бүхий этгээдүүдийн дансаар төлбөрийн гүйлгээ хийж, ажилтнуудад олгоогүй цалинг бүртгэн, ашиг багассан мэтээр тайлагнадаг. Түүнчлэн, бизнес эрхлэгчид компанийн хөрөнгийг хувийн хэрэгцээндээ ашиглаж байгууллагын зардал гэж бүртгэн татварын хөнгөлөлт эдлэхийг оролддог.

Олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг компаниуд татвараас зайлсхийхийн тулд оффшор бүсийг өргөн ашигладаг. Оффшор бүсэд компани бүртгүүлэх нь тухайн улсын татварын хөнгөлөлтийг ашиглах боломж олгодог бөгөөд ихэнх тохиолдолд эдгээр бүсүүдэд ногдол ашиг, хөрөнгийн шилжүүлэг, бизнесийн орлого зэрэгт бага татвар ногдуулдаг.

Зарим аж ахуйн нэгжүүд хуурамч НӨАТ-ын баримт бүрдүүлж, татварын буцаан олголт авах замаар хууль бусаар ашиг хүртэхийг оролддог. Мөн бараа, үйлчилгээний гүйлгээг бодит байдлаар гарсан мэтээр бүртгэх, буцаалт хийгдсэн мэтээр мэдээлэл оруулах зэргээр НӨАТ-ыг хуурамчаар ашиглах явдал түгээмэл байна.

“VAT fraud” буюу НӨАТ-ын залилан, хий бичилт нь татвараас зайлсхийх зорилгоор хуурамч гүйлгээ бүртгэх, хуурамч падаан ашиглах, үндэслэлгүй татварын буцаан олголт авах зэрэг хэлбэрээр илэрдэг бөгөөд улс орнуудын төсвийн орлогод сөргөөр нөлөөлж, шударга өрсөлдөөнийг алдагдуулж, далд эдийн засгийг бүрдүүлж байдаг. Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн хуурамч НӨАТ-ын падаан үүсгэх, давхар бүртгэл, бүртгэлгүй борлуулалт хийх, бодит үйл ажиллагаа явуулдаггүй хуурамч компаниудыг татвараас зайлсхийх хэрэгсэл болгон ашиглах хэлбэрээр хэрэгждэг.



Хуурамч падаан үүсгэх (Fake Invoicing): Татвар төлөгчид худалдан авалт хийгээгүй атлаа хуурамч падаан бүрдүүлэн, үнийн дүнгээ өсгөж, татвараас зайлсхийх замаар НӨАТ-ын буцаан олголт авах;

Бүртгэлгүй борлуулалт (Unreported Sales): Зарим бизнесүүд орлогоо албан ёсны бүртгэлд оруулахгүй, бэлэн мөнгөөр гүйлгээ хийж, НӨАТ төлөхөөс зайлсхийх;

Карусель залилан (Carousel Fraud): Улс хоорондын худалдаанд оролцогч компаниуд НӨАТ-ыг хууль бусаар буцаан олгох зорилгоор хуурамч гүйлгээ хийх;

Давхар бүртгэл (Double Invoicing): Компани нэг бараа, үйлчилгээнд хоёр өөр үнэ бүхий падаан гаргаж, нэгийг нь НӨАТ-ын тайланд тусгахгүй байх;

Хуурамч компани ашиглах (Shell Companies): Татварын залилан хийх зорилгоор байгуулсан компаниудыг ашиглан хуурамч гүйлгээ хийж, НӨАТ-ын буцаан олголт авах.

Мөрдөн шалгах ажил. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь тодорхой хохирогчгүй, далд хэлбэрээр үйлдэгддэг тул бусад төрлийн гэмт хэргүүдийн адил гэмт хэрэг гарсан дариуд нь мөрдөн шалгах ажиллагааг явуулах боломжгүй байдаг тул илрүүлэх, шалган шийдвэрлэхэд ээдрээ төвөгтэй байдаг.

Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах нь татвар төлөгчдийн татвараас зайлсхийх схемийг судлах, санхүүгийн урсгал, дансны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах зэрэг олон талт ажиллагааг багтаадаг.

Үндсэн зорилго нь хууль бус татварын схемийг илрүүлэхэд оршино. Шалгалтын ажиллагаа ихэвчлэн дүн шинжилгээ, санхүүгийн гүйлгээг мөрдөх, мэдээлэл цуглуулах, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжуудыг ашиглах зэрэг аргуудаар хэрэгждэг. Дүн шинжилгээ нь татварын гэмт хэргийн зохион байгуулалттай схемүүдийг илрүүлэх, танин мэдэхэд чиглэгддэг бол санхүүгийн мөрдлөг нь татвар төлөхөөс зайлсхийсэн мөнгөний урсгал хаана, хэрхэн шилжиж буйг тодорхойлдог.

Гэсэн хэдий ч татварын гэмт хэрэгтэй тэмцэх явдал олон сорилттой тулгарч байна. Тухайлбал, оффшор бүс нутгуудын нууцлалын түвшин өндөр байгаагаас зарим мэдээллийг авахад хүндрэлтэй байдаг. Мөн томоохон корпорациуд хууль эрх зүйн орчны цоорхойг ашиглан татвараа бууруулахын тулд олон улсын төвшинд маш нарийн схем боловсруулдаг. Түүнчлэн, цахим орчин хөгжихийн хэрээр криптовалюта, виртуал хөрөнгийн хэрэглээ ихэссэн нь хууль бус орлогоо нуун дарагдуулах шинэ арга хэрэгсэл болж, шалгалтын ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Мөрдөн шалгах ажиллагаа нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн үйлдлийг илрүүлэх, нотлох баримт бүрдүүлэх, холбогдох этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зорилготой цогц үйл явц бөгөөд татварын алба, хууль сахиулах байгууллага, санхүүгийн зохицуулах агентлагуудын хамтын ажиллагааг шаарддаг, нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ, гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааг ашиглан хэрэгждэг. Мөрдөн шалгах ажиллагааны явцад татварын тайлан, санхүүгийн гүйлгээ, үйл ажиллагааны бүртгэл, хувь хүн, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн зэргийг нарийвчлан судалж, татвараас зайлсхийх, хуурамч тайлан гаргах, мөнгө угаах гэмт хэргийн ул мөрийг тогтоох шаардлагатай.

Шалгалтын ажиллагааны эхний шат нь урьдчилсан судалгаа, мэдээлэл цуглуулах, цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх үйл явц бөгөөд энэ нь тухайн хэрэгт холбоотой анхны сэжүүрийг олох, шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэх үндэс болно. Татварын байгууллагын мэдээллийн сангаас шалгаж буй этгээдийн татвар төлөлтийн мэдээллийг гаргуулан авч, татвар төлөгчийн орлого, зарлага, тайлангийн зөрүүг шалгах, санхүүгийн байгууллага, аудитын компаниуд болон бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, татварын зөрчлийн шинж чанарыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой.

Хоёр дахь шат нь нотлох баримт цуглуулах үе юм. Энэ шатанд үзлэг, нэгжлэг хийж тухайн этгээдийн санхүүгийн анхан шатны баримт, материалуудыг хураан авч, дүн шинжилгээ хийж, зөрчилтэй мэдээллийг тогтооно. Татвар төлөгчийн бизнесийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн шинжилгээгээр орлогоо зориудаар нуун дарагдуулсан эсэх, хуурамч тайлан гаргасан эсэхийг тогтооно. Үүнээс гадна, гуравдагч этгээд буюу хамтран ажилладаг байгууллагууд, нягтлан бодогчид, санхүүгийн зөвлөхүүдийн оролцоотойгоор хэрэгт холбогдсон этгээдүүдийг тогтоох шаардлагатай.

Орчин үед технологийн хурдацтай хөгжил нь татварын гэмт хэргийг илрүүлэх аргачлалыг шинэчлэхийг шаардаж байна. Ялангуяа их өгөгдлийн дүн шинжилгээ, хиймэл оюун ухаан, санхүүгийн урсгалыг хянах программ хангамжийн хэрэглээ зайлшгүй хэрэгцээтэй байна. Тухайлбал, криптовалютын арилжаа, оффшор бүс нутгаар хийгдэх банкны шилжүүлэг, виртуал хөрөнгийн хөдөлгөөнийг хянах нь өнөөгийн нөхцөлд улам бүр ач холбогдолтой.

Тухайн үйлдэл хэзээ, хэрхэн хийгдсэн, ямар арга ашигласан, ямар этгээдүүд оролцсон болон хуулийн ямар зохицуулалтыг зөрчсөн болохыг нарийвчлан тогтоох шаардлагатай. Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд, санхүүгийн байгууллагууд, төрийн албан хаагчдын оролцоотой үйлдэгддэг.

Баримтжуулалтын эхний шатанд, татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдийг тогтоох шаардлагатай. Энэ нь хувь хүн, аж ахуйн нэгж эсвэл тэдний харьяалагдах бизнесийн сүлжээнд хамаарч болох тул тухайн этгээдийн татварын түүх, орлого, санхүүгийн тайлан, гүйлгээ зэргийг нарийвчлан шалгах хэрэгтэй. Үүнээс гадна, тухайн этгээдийг татвараас зайлсхийсэн эсэхийг тодорхойлохын тулд орлого, зарлагын бүртгэлийг нягтлах, санхүүгийн тайлангийн мэдээллийг бодит байдалтай нь харьцуулан дүн шинжилгээ хийх шаардлагатай.


Дараагийн шатанд, гэмт хэргийн механизмыг тогтооно. Зарим тохиолдолд компаниуд хуурамч данс үүсгэж, орлогоо бууруулан тайлагнаж, зардлаа хуурамчаар нэмэгдүүлэн татварын төлбөрөө багасгахыг оролддог. Мөн татварын тайлангаа худал мэдүүлэх, НӨАТ-ын баримтыг хуурамчаар бүртгүүлэх, гаалийн татвараас зайлсхийх зорилгоор барааны үнэлгээг бууруулах, бүртгэлгүй ажиллах хүч ашиглах зэрэг олон төрлийн арга хэрэглэдэг. Энэ бүхнийг илрүүлэхийн тулд татварын тайлан, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, банкны гүйлгээ, гаалийн бүрдүүлэлтийн баримт зэрэг эх сурвалжуудыг нэгтгэн дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Түүнчлэн, татвараас зайлсхийсэн этгээдүүдийг хууль сахиулах байгууллагууд болон татварын алба, банк санхүүгийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудтай хуйвалдсан эсэхийг тогтоох шаардлагатай. Үүнд, татварын байцаагч, гаалийн ажилтнууд авлига авч, хяналт шалгалтаас зайлсхийх нөхцөл бүрдүүлсэн эсэхийг судлах, мөн авлигын гүйлгээ, харилцан тохиролцсон үйлдлүүд, эрх бүхий албан тушаалтны оролцоог судалж, санхүүгийн мөрдлөг хийх шаардлагатай. Нөгөө талаас, олон улсын хэмжээний татвараас зайлсхийх схемүүдийг судална, учир нь оффшор бүс дэх нууц данс, гадаадын компаниудад хөрөнгө шилжүүлэн татварын хяналтаас нуугдах, гадаад улс орнуудад худал татварын тайлан гаргах зэрэг нь олон улсын хэмжээнд ихээр тохиолддог тул холбогдох мэдээллийг олон улсын хамтын ажиллагааны механизмуудаар дамжуулан авч үзэх хэрэгтэй.

Шалгалтын ажиллагааны хүрээнд тухайн үйлдэлд оролцсон этгээдүүдийг тогтоох, ашигласан арга барилыг судлах, хуурамч санхүүгийн схемүүдийг илрүүлэх, олон улсын татварын орчныг харгалзан үзэх, төрийн албан хаагчид авлига авсан эсэхийг шалгах, мөн төрд учирсан хохирлын бодит хэмжээг тодорхойлон, хууль бус орлогыг илрүүлж, нөхөн төлүүлэх шаардлагатай юм.


Эрүүгийн нөхцөл байдал. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд эдийн засгийн гэмт хэрэг нийт 336, Улаанбаатар хотод 255 буюу 75,9%, орон нутагт 81 буюу 24,1% бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 136 буюу 68%, нийслэлд 113 буюу 79,6%, орон нутагт 23 буюу 39,7%-иар тус тус өссөн. Хэргийн илрүүлэлт мөн онд 22,8%, нийслэлд 15,3% байгаа нь өмнөх оны мөн үеэс улсын хэмжээнд 2,6 нэгжээр, нийслэлд 2,5 нэгжээр тус тус өссөн байна.⁴

Цагдаагийн байгууллагад 2015-2024 онд бүртгэгдсэн эдийн засгийн гэмт хэргийн статистик мэдээ:

Хүснэгт 1. Гэмт хэргийн үзүүлэлт



Хүснэгт 2. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг сүүлийн 10 жилээр




Цагдаагийн байгууллагын статистик мэдээллээс үзэхэд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг 2017 онд 20, 2018 онд 23, 2019 онд 19, 2020 онд 26, 2021 онд 84, 2022 онд 109, 2023 онд 105, 2024 онд 158 бүртгэгдсэн нь энэ төрлийн гэмт хэрэг жил ирэх бүр нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.


Улсын хэмжээнд 2024 онд татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг 158 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 53 нэгжээр буюу 50,5%-иар, хэргийн илрүүлэлт 14%-тай байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 1,5%-иар өссөн байна. “Т-21” систем, динамикийн загварчлалын дагуух гэмт хэргийн прогнозоор 2023 – 2040 он хүртэлх хугацаанд гэмт хэрэг жилд дунджаар 3,6 хувь өсөх төлөвтэй байна.

⁴ “Гэмт хэргийн тоо судалгаа”, Эрүүгийн цагдаагийн алба, Улаанбаатар хот 2024 он

Хүснэгт 3. Нийслэл



Хүснэгт 4. Орон нутаг



Дүгнэлт

Нэг. Монгол Улсад сүүлийн жилүүдэд эдийн засгийн гэмт хэрэг тэр дундаа татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг үйлдэгдэх явдал ихсэж байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдаж байна. Цагдаагийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж буй этгээдүүдтэй эрчимтэй тэмцэж байгаа ч даяаршиж буй өнөөгийн нийгэмд татварын гэмт хэрэг нь олон улсын шинжтэй болж, үндэстэн дамнаж үйлдэгдэж байна.

Хоёр. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь санхүүгийн болон эрх зүйн зохицуулалтыг урвуулан ашиглаж, олон төрлийн үйлдлийн аргаар хэрэгждэг. Орлогоо нуух, хуурамч зардал бүрдүүлэх, оффшор бүс ашиглах, олон улсын санхүүгийн схемүүдийг ашиглан төвөгтэй гүйлгээ хийх зэрэг арга замууд нь татварын хяналт шалгалтаас зайлсхийх үндсэн хэрэгсэл болдог. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, санхүүгийн хяналт шалгалтын арга хэмжээг чангатгах шаардлагатай байна.

Гурав. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд санхүүгийн мөрдлөгийн аргуудыг хөгжүүлэх замаар мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг сайжруулах шаардлагатай. Татварын гэмт хэргийг үр дүнтэй баримтжуулах, мөрдөн шалгах нь зөвхөн тухайн улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хангаад зогсохгүй олон улсын санхүүгийн системийн ил тод байдлыг хамгаалах ач холбогдолтой юм.

Дөрөв. Татварын гэмт хэрэг нь олон улсын шинжтэй, нарийн төвөгтэй схемүүдийг ашиглан үйлдэгддэг учраас олон улсын хамтын ажиллагааг сайжруулах, криптовалют, блокчейн технологи ашигласан татвар, мөнгө угаах гэмт хэргүүдийг шалгах аргачлалд технологийн дэвшлийг ашиглах нь зайлшгүй чухал болж байна.

Тав. НӨАТ-ын залилан нь далд эдийн засгийг улам бүр тэлж, улсын төсвийн орлогыг бууруулж, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлдөг. Татварын орлого багассанаар төрийн

үйлчилгээний санхүүжилт дутагдаж, эдийн засгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй болж байна.

Ашигласан материал

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Эрүүгийн хууль
2. Монгол Улсын Татварын ерөнхий хууль

Ном, сурах бичиг:

1. Монгол хэлний их их тайлбар толь (цахим)
2. С.Чинбат “Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн өнөөгийн байдал” Улаанбаатар хот 2016 он
3. “Эдийн засгийн гэмт хэргийг илрүүлэх аргачлал, онол, практик”, Цагдаагийн ерөнхий газар, 33-35 дугаар тал, Улаанбаатар хот 2018 он
4. “Гэмт хэргийн тоо судалгаа”, Эрүүгийн цагдаагийн алба, Улаанбаатар хот 2024 он